БАТЛАВ:
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БАТ-ЭРДЭНЭ

БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ҮЗҮҮЛЭГ ДЭГЛЭЛТ, ҮЗМЭРИЙН ИНТЕРЬЕРИЙН ЗУРАГ, ЦУГЛУУЛГА, ҮЗМЭРИЙН ТОНОГЛОЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Дугаар: АД/26/01 Улаанбаатар хот

	Захиалагч байгууллага, хаяг	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Денверийн гудамж.
	Даалгавар боловсруулах үндэслэл	• Монгол Улсын Засгийн газраас баталсан "Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль"-ийн 2 дугаар хавсралт-"Байгалийн түүхийн музейн үзүүллэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж" УТ2603400590 /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/; • "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей"-н шинэ цогцолборын барилгын зураг төсөл (ЕГ шифр: ХАТ-18ө/19, "Хатанбаатар" ХХК, 2025 он). • Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн шинэ цогцолборын барилгад музейн үзүүллэг дэглэлт, үзмэрийн интерьер, тоног төхөөрөмж, дижитал систем, дагалдах үйлчилгээний иж бүрэн шийдлийг Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн үзэл баримтлалд нийцүүлэн бараа нийлүүлэлт болон дагалдах ажил, үйлчилгээний иж бүрэн хэлбэрээр хэрэгжүүлэх зорилгоор энэхүү техникийн даалгаврыг боловсруулав.
	Зорилго	Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөөнд нийцүүлэн барилгын дотоод орчин, үзүүллэг дэглэлт, интерьер, тоног төхөөрөмж, дижитал системийг Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, норм норматив баримт бичигт нийцүүлэн төлөвлөж, нийлүүлж, суурилуулан ашиглалтад бэлэн, олон улсын жишигт нийцсэн музейн орчныг бүрдүүлж хүлээлгэн өгөхөд оршино.
	Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал	• Барилга байгууламжийн нэр: "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей"-н барилга. • Байршил: Хан-Уул дүүргийн 11-р хороо, Богд Хан уулын нутаг дэвсгэрт байрлах 66,332 м2 талбайд баригдаж буй "Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей" шинэ барилга. • Давхрын тоо: Барилга нь 3 давхар, зоорийн давхартай. • Хүчин чадал: 1-3 давхар, А-Б-В-Г-Д блок барилгуудаас бүрдэх, өдөрт 4,400 хүн, жилд 1,500,000 хүн хүлээн авах хүчин чадалтай.

		• Хийцлэл: Цутгамал, төмөр бетон араг бүтээцтэй, гадна дотор хана хөнгөн блок дүүргэлттэй, металл фасадтай.
	Ажлын хамрах хүрээ	**Талбайн хэмжээ:** Барилга нь А–Б–В блок бүхий нийт 33,000 м² талбай. • А блок – 3 давхар, зоорийн давхартай; • Б блок-3 давхар, зоорийн давхартай; • В блок – 2 давхар; **А блок** Зоорийн давхар: • Оффис • Лаборатори • Хэвлэх цех • Мужаан цех • Нийтийн хэсэг • Ажилчдын хоолны заал, бэлтгэх хэсэг • Хүүхэд хамгааллын өрөө, • Техникийн өрөөнүүд **Нэгдүгээр давхар:** • Оффис • Номын сан • Лобби (угтах хэсэг, тээш хадгалах хэсэг, өлгүүр) • Түр үзэсгэлэнгийн танхим • Музейн бэлэг дурсгалын дэлгүүр • Кофе шоп • Амфитеатр (задгай) • Анхны тусламжийн хэсэг • Нийтийн эзэмшлийн талбай • Техникийн өрөөнүүд **Хоёрдугаар давхар:** • Орчлонгийн үүсэл, хөгжил танхим • Геологи танхим • Газарзүйн танхим • Биологийн төрөл зүйлийн танхим • Нийтийн эзэмшлийн талбай • Ногоон байгууламж • Техникийн өрөөнүүд **Гуравдугаар давхар:** • 250 хүний суудалтай хурлын танхим • Боловсрол, сургалтын танхимууд • Ресторан, халуун цех, агуулах • Кофе шоп • Хүүхдийн тоглоомын өрөө • Хүүхэд хамгаалах өрөө • Нийтийн эзэмшлийн талбай • Дээврийн задгай талбай, ногоон байгууламж • Техникийн өрөөнүүд **Б блок** **Зоорийн давхар:** • Сан хөмрөгийн өрөөнүүд • Оффис • Төрөлжсөн лаборатори • Техникийн өрөөнүүд • Нийтийн эзэмшлийн талбай **Нэгдүгээр давхар:**

		• Хүний үүсэл, хөгжил танхим • Шинжлэх ухааны танхим • Техникийн өрөөнүүд • Нийтийн эзэмшлийн талбай • Пандус **Хоёрдугаар давхар:** • Биологийн төрөл зүйлийн танхим • Ногоон байгууламж • Суудлын доорх орон зай • Нийтийн эзэмшлийн талбай • Техникийн хэсэг **Гуравдугаар давхар:** • 75-100 хүний суудалтай дом театр • Нийтийн эзэмшлийн талбай • Техникийн өрөөнүүд **В блок** **Нэгдүгээр давхар:** • Амьдралын үүсэл, хувьсал танхим • Нийтийн эзэмшлийн талбай • Техникийн өрөөнүүд • Угтах хэсэг **Хоёрдугаар давхар:** • Амьдралын үүсэл, хувьсал танхим • Боловсрол, сургалтын танхимууд • Нээлттэй сан хөмрөг, лаборатори • Нийтийн эзэмшлийн талбай • Техникийн өрөөнүүд **Гадна талбай:** • Соёл, олон нийтийн талбай • Боловсрол, сургалтын хэсэг • Байгалийн ногоон бүс • Ариун цэврийн байгууламжууд **Хамрах нийт талбай:** • Байнгын үзүүллэгийн 7 танхим, 34 хэсэг бүхий 11,794 $м^2$ • Бусад талбай: 21,206 $м^2$ • Нийт талбай: 33,000 $м^2$ + гадна талбай, ногоон байгууламж, ландшафт
	Тендер шалгаруулалтын нэр	"Байгалийн түүхийн музейн үзүүллэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж" /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/
	Багцын мэдээлэл	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ. Үүнд: Багц-01: Музейн үзүүллэг дэглэлт, үзмэрийн интерьер, үзүүлэнгийн тоноглол, дагалдах ажил, үйлчилгээ- 169,748,143,000.00 төгрөг; /зуун жаран есөн тэрбум долоон зуун дөчин найман сая хоёр зуун гурван мянган төгрөг /. **Тухайн багцад хамаарах бараа, ажил, үйлчилгээ:** 1. Үзэсгэлэнгийн тэнхимийн бэлтгэл, тохижилт, үйлчилгээ 2. Интерьерийн зураг, төсөв, магадлалын дүгнэлт 3. Шилэн хорго 4. Үзүүллэгийн гэрэлтүүлэг 5. Экосистемийн орчин бүрдүүлэлт

		6. Үзмэрийн дагалдах тоноглол 7. Үзүүллэгийн дижитал тоног төхөөрөмж 8. Баримтжуулалтын студи /тоног төхөөрөмж 9. Тусгай гэрэлтүүлэг, замын систем 10. Үзүүллэгийн дижитал контент бүтээх 11. Аюулгүй байдлын систем 12. Дом театр 13. Оффисын нэвтрэх хяналтын систем 14. Брэнд дизайн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл 15. Үзмэр боловсруулалт, сэргээн засварлалт, модель бүтээх 16. Үлэг гүрвэлийн каст, модель, үзмэр худалдан авах 17. Үзүүллэгийн хаяг, тайлбар, орчуулга 18. Сэргээсэн амьдрах орчин, механик загвар 19. Түр үзэсгэлэнгийн танхим 20. Хурлын танхим 21. Боловсрол сургалтын 3 танхим 22. Гадна талбайн тохижилт 23. Зогсоолын цахилгаан түгээгүүр, ухаалаг систем 24. Сургалтын танхимын тохижилтын багцын задаргаа 25. Лазер болон цаасан хэвлэлийн тоног төхөөрөмж 26. Жижиг хурлын танхим 27. Нийтийн эзэмшлийн талбай 28. Зогсоолын хаалт 29. Угтах хэсэг /лобби 30. Гаднах лед дэлгэц / барилга 31. Сав баглаа боодол, хамгаалалт 32. Лабораторийн тоног төхөөрөмж 33. Сан хөмрөг 34. Чийрэгжүүлэлтийн танхим 35. Бэлэг дурсгалын дэлгүүр 36. Кофе шоп 37. Номын сан 38. Хүүхэд саатуулах хэсэг Тухайн багцын тендерт дараах зардлыг өөрийн тендерт тусгаж ирүүлнэ. Үүнд: ✓ **Магадалшгүй зардал** - 17,836,806,000.00 төгрөг; ✓ **Зөвлөх үйлчилгээний зардал** - 20,000,000.00 төгрөг. Багц-02: Музейн үйл ажиллагааг дэмжих ажлын байрны тоноглол, тавилга - 891,350,000.00 төгрөг; Багц-03: Музейн үйл ажиллагааг дэмжих ажлын байрны техник хэрэгсэл - 1,571,558,000.00 төгрөг; Багц-04: Музейн зочин үйлчилгээ, нийтийн хоолны хэсгийн тоног төхөөрөмж, тавилга - 4,330,949,000.00 төгрөг; **Тухайн багцад хамаарах бараа, ажил, үйлчилгээ:** 1. Ресторан 2. Ажилчдын цайны газрын тоног төхөөрөмж, ажил үйлчилгээ Багц-05: Музейн ашиглалтад шаардлагатай тээврийн хэрэгсэл - 1,826,000,000.00 төгрөг;
	Ажлын үе шат, гүйцэтгэх ажлын бүрэлдэхүүн	Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэлт болон дагалдах ажил, үйлчилгээний хүрээнд дараах ажлыг иж бүрнээр гүйцэтгэнэ. Үүнд:

1. Зураг, техникийн шийдэл боловсруулах үе шат

Гүйцэтгэгч нь захиалагчийн баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод үндэслэн зураг, техникийн шийдлийг боловсруулж, нийлүүлэх бараа, тоног төхөөрөмжийн жагсаалт, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт болон холбогдох төсөв, зардлын тооцоог зураг төслийн шатанд нарийвчлан тодорхойлж захиалагчаар батлуулна.

Захиалагчийн боловсруулсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг зураг, техникийн шийдэл боловсруулах шатанд захиалагчтай зөвшилцөн, ажлын үндсэн хамрах хүрээ, зориулалт, төсвийн хүрээг өөрчлөхгүйгээр тодотгож, нарийвчлан өөрчлөхийг зөвшөөрнө.

Үүнд:

- Интерьер, үзүүллэг дэглэлт, тоног төхөөрөмжийн байршуулалтын зураг боловсруулах;
- Мультимедиа, дижитал системийн техникийн шийдэл боловсруулах;
- Гэрэлтүүлэг, цахилгаан, дата, сүлжээний шийдэл боловсруулах;
- Суурилуулалтын ажлын зураг боловсруулах;
- Захиалагчийн боловсруулсан дэд даалгавар, техникийн тодорхойлолт;

1.1. Зураг, техникийн шийдэл боловсруулахад баримтлах шаардлага

Зураг төсөл боловсруулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, норм нормативын баримт бичигт нийцүүлэн, олон улсын музейн стандарт шаардлага, орчин үеийн хэв шинж, соёл урлаг, үзвэр үйлчилгээний жишгийг баримтална.

1.1.1. Интерьерийн ерөнхий шийдэл

- ✓ Хүлээн авах хэсгийг байгалийн өвөрмөц тогтоц, онцлогийг шингээсэн ханын монументал хийц, гантиг чулуун хана, байгалийн чулуу ашигласан интерьерийн шийдлээр төлөвлөх;
- ✓ Үзүүллэгийн танхимуудад нарны шууд тусгал орохгүй байхаар төлөвлөх;
- ✓ Дотор интерьерийн материал нь олон улсын стандарт, гал болон эрүүл ахуйн шаардлага хангасан гипс, байгалийн чулуу, үнэт металл зэрэг материал байх;
- ✓ Хүнд жинтэй палеонтологийн үзмэрүүд байрлуулах нөхцөлийг тооцсон байх;
- ✓ Хурлын танхимын таазны интерьерийг таазны зурагтай уялдуулан төлөвлөх;

1.1.2. Барилгын төлөвлөлт, хүртээмж

- ✓ Музейн төв болон доторх бүх хаалга гадагш онгойдог байхаар төлөвлөх;
- ✓ Барилгын бүх хэсэгт аюулгүй ажиллагаа, аваарын тэмдэглэгээг норм стандартын дагуу төлөвлөх;

- ✓ Тусгай хэрэгцээт иргэдийн бие даах шаардлагад нийцсэн орон зайг бий болгох;

1.1.3. Инженерийн системийн уялдаа

- ✓ Гал унтраах болон агааржуулалт, хөргөлтийн системийг үзүүллэгийн танхим, сан хөмрөгийн онцлогт тохируулан интерьерийн шийдэлтэй уялдуулан төлөвлөх;

1.1.4. Цахилгаан, гэрэлтүүлгийн шийдэл

- ✓ Цахилгаан шугам сүлжээ нь галд тэсвэртэй, олон улсын стандарт хангасан утсаар хийгдсэн, далд байрлалтай, чийдэн хамгаалалтын бүрхүүлтэй байх;
- ✓ Цахилгааны унтраалгын суурь битүү байх;
- ✓ Зөөврийн гэрэлтүүлэгчийн цахилгаан дамжуулагч утас резинэн бүрээстэй байх;
- ✓ Ерөнхий болон давхрын, танхимуудын унтраалгыг өрөөний гадна байрлуулах;
- ✓ Шаардлагатай тохиолдолд шаланд суурилсан разетка төлөвлөх;

1.1.5. Материалын аюулгүй байдал

- ✓ Галд шатамхай синтетик материал (пенопласт, хөөсөнцөр, EPS, XPS, полиуретан зэрэг) ашиглахгүй байх;

1.1.6. Үзүүлгийн технологийн шийдэл

- ✓ Орчин үеийн музейн жишгийн дагуу видео, виртуал болон интерактив үзүүлгийн хэсгүүд төлөвлөх;

1.1.7. Хурлын танхимын олон зориулалт

- ✓ 250 хүний суудалтай хурлын танхимыг дараах зориулалтаар ашиглах боломжтойгоор төлөвлөх. Үүнд:
  - Хурал, зөвлөгөөн;
  - Кино театр;
  - Хүүхдэд зориулсан танин мэдэхүйн контент;
  - Концерт, жүжиг;
  - Хүлээн авалт, ёслолын арга хэмжээ гэх мэт.

2. Зураг боловсруулах үе шат, иж бүрдэл

2.1. Загвар зургийн үе шат

- ✓ Загвар зургийн үе шатанд музейн жишгийг агуулсан интерьерийн ерөнхий концепц, материал, өнгө, гэрэлтүүлгийн шийдлийг боловсруулж, танхим, өрөө тус бүрийн 3 хэмжээст (3D) зургийг боловсруулна.
- ✓ Загвар зургийг захиалагчаар баталгаажуулсны үндсэн дээр ажлын зургийг боловсруулж эхэлнэ.

2.2. Ажлын зургийн үе шат

Ажлын зураг нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- ✓ Ханын дэлгээс, ханын гэрэлтүүлэг;
- ✓ Тааз, гэрэлтүүлгийн байгуулалт;

- ✓ Үзүүллэгийн танхимын гэрэлтүүлгийн тооцоо, схем зураглал;
- ✓ Үзүүллэгийн болон тайзны гэрэлтүүлгийн суурь;
- ✓ Дуу түгээх тоноглолын суурь тооцоо;
- ✓ Цахилгаан хангамж;
- ✓ Агаар сэлгэлтийн систем;
- ✓ Галын дохиолол, галын автоматик;
- ✓ Технологийн байгуулалт;
- ✓ Нарийвчилсан хэсэглэл зургууд;
- ✓ 3 хэмжээст зургууд;
- ✓ Тавилгын байгуулалтын зураг;
- ✓ Төсөв, зардлын тооцоо;
- ✓ Магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах.

Ажил гүйцэтгэх аргачлал:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн дагуу боловсруулж, баталгаажсан эх загвар зураг болон магадлал хийлгэсэн иж бүрэн ажлын зураг, төсөв болон экстерьерийн зураг төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь-1, хуулбар хувь-1 хэвлэмлээр, файл хэлбэрээр CD-д бичиж 2 хувь хүлээлгэн өгнө.

3. Ашиглах материал

Монгол Улсын хуулиуд:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль;
- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Номын сангийн тухай хууль;
- ✓ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Боловсролын тухай хууль;
- ✓ Аялал жуулчлалын тухай хууль;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- ✓ Галын аюулгүй байдлын тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай;
- ✓ Гамшгаас хамгаалах тухай хууль;
- ✓ Шинжлэх ухаан технологийн тухай хууль;
- ✓ Хүүхдийн эрхийн тухай хууль;
- ✓ Хүүхэд хамгааллын тухай хууль;

Норм, норматив, стандарт:

- ✓ Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНбД 23-02-08;
- ✓ Олон нийтийн барилгын норм дүрэм БНбд 31.03.03;
- ✓ Театры СНиП II-Л. 20-69;
- ✓ Үзмэрийн танхимын акустик /Акустика залов СНиП 23-03-2003II-Л. 20-69;
- ✓ Олон улсын цахилгаан техникийн хорооны таних тэмдэглэгээ MNS IEC 60617;
- ✓ Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5634:2006;
- ✓ Цахилгаан тоног төхөөрөмж, гүйдэл дамжуулагчийн таних тэмдэглэгээ. MNS 3757-16:2015;
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын стандарт ISO27001:2022;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх MNS:6056:2003;
- ✓ Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21.02.02 /БНбД 21.04.05/;
- ✓ Төсөв зохиох дүрэм БНбД 3.05.06-90;
- ✓ Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө;
- ✓ ЮНЕСКО-гийн Соёлын илэрхийллийн олон янз байдлыг хамгаалах ба дэмжих тухай конвенц 2005 он;
- ✓ ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц 1972 он;
- ✓ Соёлын эд зүйлийг хууль бусаар хилээр оруулах, гаргах түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай конвенц 1970 он;
- ✓ Музейн болон цуглуулгыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх ба тэдгээрийн олон янз байдал, нийгэм дэх үүргийн талаарх зөвлөмж 2015 он;
- ✓ Хоол, ундааны үйлчилгээний хүртээмжийн шаардлагууд Ногоон Ресторан Холбооны Стандартууд;
- ✓ Музейн кафенуудад улам бүр нэвтрүүлж буй байгаль орчны гэрчилгээний стандартууд;
- ✓ Хаягдал бууруулах, тогтвортой эх үүсвэрт анхаарах IAAPA (Олон улсын амралт, чөлөөт цагийн паркуудын холбоо) Хоол, ундааны стандартууд
- ✓ Олон үзэгчтэй байгалийн шинжлэх ухааны музейнүүдэд түгээмэл нэвтрүүлдэг;
- ✓ Дараалал менежмент, үйлчилгээний үр ашгийн удирдамжууд HACCP (Аюулын дүн шинжилгээ ба хяналтын чухал цэгүүдийн) Хүнсний аюулгүй байдлын систем;
- ✓ Музейн хоол, ундааны үйлчилгээнд шаардлагатай хүнсний аюулгүй байдлын протоколууд;
- ✓ Хүнс боловсруулалтын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт;

		✓ Эко барилгын үндэсний болон олон улсын зөвлөмж, стандартууд; ✓ Хаягжуулалт хийх стандарт ✓ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025 оны ССАЖЗЯ/01/-гг-2025 (142) гэрээт ажлын тайлан. **4. Онцгой нөхцөл** ✓ Интерьерийн зураг төслийн төлөвлөлт, шийдэл, зургийн иж бүрдэл нь энэхүү ажлын даалгавраар хязгаарлагдахгүй бөгөөд олон улсын стандарт, мэргэжлийн байгууллагын шаардлагыг хангасан зураг төсөл зохиоход даалгаврын үүрэг оршино. ✓ Гэрэлтүүлэг, цахилгаан тоноглолууд нь эрчим хүчний хэмнэлттэй шийдлийг тусгасан байх. /А-с доошгүй/ ✓ Тусгай хэрэгцээт иргэдийн орц, гарц, пандусыг норм дүрмийн дагуу төлөвлөх; ✓ Тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө төлөвлөх, тоноглох; ✓ Аваарын болон галын орц гарц нормын дагуу төлөвлөгдсөн байх; ✓ Ажлын зураг төсөл боловсруулах явцад захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцөх; ✓ Интерьерийн ажлын зураг төсвийг эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэсэн байна. **5. Архитектур төлөвлөлтөд тавигдах тусгай шаардлага** **Үзүүллэг, үзэсгэлэнг нарийвчлан тодорхой гаргах.** ✓ Үзмэр цуглуулгын төрөл зүйлийг дэглэлтийн түвшинд ялгарах байдлаар хийх; ✓ Эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах; ✓ Эх үзмэрээс авсан санаа, өнгө төрхийг хадгалсан байх; ✓ Хийцлэл гүйцэтгэлийг бат бөх, эдэлгээ бүхий цэвэр үзэмжтэй хийх; ✓ Чадварлаг нарийн урласан байх; ✓ Үндэсний хэв маяг оруулсан байх; ✓ Олон улсын зөвлөх үйлчилгээний Лорд культурал ресурсис компанийн багц 1-4 тайланг ашиглах.
	Ерөнхий агуулга	Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн дотоод интерьер нь орчин үеийн интерьер дизайны хийц материалаар мэргэжлийн гэрэл гэрэлтүүлэгтэй уялдуулан олон улсын стандарт шаардлагад нийцсэн хийц загвартай байна. Үзүүллэгийг орчлонгийн үүсэл хөгжил, амьдралын үүсэл хөгжил, геологи, газар зүй, биологийн олон янз байдал, хүний үүсэл хөгжил, шинжлэх ухаан танин мэдэхүй гэсэн бүтэцтэйгээр төлөвлөж доорх агуулгыг тусгасан дэглэлтийг хийнэ. Үүнд: ✓ Орчлонгийн үүсэл, хөгжил: Их тэсрэлт явагдсанаас эхлэн орчлон ертөнц үүсэж, галактик бүрэлдэх, одод, түүний төрөл, нарны үүсэл, нар ба гарагуудын байрлал,

		хөдөлгөөн, дэлхийн дотоод бүтэц, бүрхүүл, нэн эртний дэлхий, супер тив, тив үүсэх тектоник хөдөлгөөн зэргийн талаарх ойлголт; ✓ Геологи: Эрдэс, чулуулаг, ашигт малтмал, тэдгээрийн гарал үүсэл, ангилал, тархалт, эрдэс баялгийн ордын үүсэл, олборлолт, нөхөн сэргээлт, дэлхийн болон Монгол орны тектоник, стартиграфын ангилал, геологийн хөгжлийн түүхийг таниулах; ✓ Газарзүй: Дэлхийн газарзүй, хуурай газрын экосистем, Монгол орны газарзүй, дөрвөн улирлын тухай танин мэдэхүйн ойлголтыг өгөх; ✓ Биологийн олон янз байдал: Дэлхийн биологийн олон янз байдал, Монгол орны дөрвөн улирлын гео-экологийн онцлог байдлыг илэрхийлсэн байгалийн экосистем орчин нөхцөл, газарзүйн бүс бүслүүрт нь ургамал, мөөг, сээр нуруугүйтэн (хавтгай хорхой, дугариг хорхой, цагаригт хорхой, зөөлөн биетэн, үе хөлтөн), сээр нуруутан (загас, хоёр нутагтан, мөлхөгч, шувуу, хөхтөн) амьтан, тэдгээрийн ангилал, зүйлийн бүрэлдэхүүн, амьдрах орчин, амьдралын эргэлт, тархалт, хамгаалал зэрэг ойлголтыг өгөх; ✓ Амьдралын үүсэл хөгжил: Амьдрал үүсэж эхэлсэн эртний Архейн эрин үеэс одоо үе хүртэлх Дөрөвдөгчийн эринд үүсэж бий болсон эртний ургамал, сээр нуруугүйтэн, сээр нуруутан амьтдын олдвор, цуглуулгыг амьдралын үүсэл хөгжлийн он цагийн дараалаар шинжлэх ухааны танин мэдэхүйн мэдээллээр баяжуулан үзүүлэх; ✓ Хүний үүсэл, хөгжил: Хүний үүсэл, хөгжлийн үе шат, хувьслын үе шатууд, эртний хүмүүсийн амьдрал, хүний олон янз байдал зэрэг ойлголтыг өгөх; ✓ Шинжлэх ухаан, танин мэдэхүй: Хэрхэн, яаж гэсэн асуултад хариулагдах зарчимд тулгуурлан байгалийн шинжлэх ухааны хууль, зүй тогтол, газарзүй, байгаль цаг уурын үзэгдэл, хүний нөлөөллөөр байгальд учирч буй эерэг, сөрөг өөрчлөлтийн тухай ойлголтуудыг туршин үзэх, тоглонгоо суралцах, сонсох зэрэг оролцоот хэлбэрээр мэдэрч, суралцана. Үүнд: ✓ Дэлхийн литосферийн хөдөлгөөн буюу тектоник хавтангийн шилжилт хөдөлгөөнөөр нэн эртний дэлхийгээс эхлээд одоогийн дэлхий дээрх тивүүдийн үүсэл, өөрчлөлт, уул нурууд үүсэх, галт уул дэлбэрэх, газар хөдлөх процесс; ✓ Мезозойн эриний сүүлчийн галав болох Цэрдийн галавын үеийн байгалийн орчинд Монгол орноос олдсон үлэг гүрвэлүүдийн зүйлүүдийн бодит биеийн хэмжээ, галбир төрх, хөдөлгөөн; ✓ Өндөр уул, нурууд, хүрхрээ, шилмүүст ой, навчит ой, хээр, цөл, элсэн манхан, далайн давлагаа зэрэг ландшафтын онцлог, цахилгаан цахих, аянга буух, солонго татах, бороо, цас орох, салхи зэрэг цаг агаарын үзэгдлүүд; ✓ Монгол орны дөрвөн улирлын солигдол байгаль, цаг уурын онцлог;

		✓ Ургамал, амьтны гадаад, дотоод бүтэц, үржил, хөгжил, амьдралын эргэлт, идэш тэжээлийн хэлхээ, биомассын суварга, байгаль дахь хүчилтөрөгч, азот, фосфор, усны эргэлт зэргийн тухай ойлголт, экосистем болон зүйлийн олон янз байдал; ✓ Физикийн шинжлэх ухааны үндсэн ухагдахууны тухай ойлголт; ✓ Бодисын шинж чанар, төлөв байдал, төлөвийн шилжилт, нэвчих үзэгдэл, химийн элемент, химийн нэгдэл зэрэг ойлголт; ✓ Уул уурхай, сэргээгдэх эрчим хүчний ажиллах зарчим; ✓ Дом театрт гараг, сар, од эрхэс, оддын бөөгнөрөл, нар, галактик, сүүлт од, солир, эх газар, далайн амьдралын тухай шинжлэх ухааны танин мэдэхүйн ойлголтыг сонирхолтой богино хэмжээний киног виртуал хэлбэрээр үзүүлэх ✓ Гадна талбайн үзүүллэг: Үзэгчид музейн танхимд үзсэн мэдлэгээ бататгах, амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх амьд ургамал бүхий амьтны хөдөлгөөнт, дуут баримал цэцэрлэгт хүрээлэнг гадна талбайд байгуулах ✓ Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн шинэ өнгө төрх брендбүүк тодорхойлох, орчин үеийн шинэлэг загвараар бий болгон олон нийтэд таниулан сурталчлах, олон нийтэд хүргэх мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа, тараах материал, компанийн дотооддоо ашиглах албан бичиг, бэлэг дурсгалын материалууд гэх мэт маркетингийн бүхий л элементүүдийг стандартжуулан дагаж мөрдөхөд бэлтгэх. ✓ Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэсэг
	Байгууламжийн гаднах агуулга	✓ Ногоон байгууламж /мод тарих талбай, цаг агаарын станц, онцгой байдлын цуглах цэг, явган замын гэрэлтүүлэг, ундны ус уух цэг 2 хэсэгт, ариун цэврийн байгууламж, зарлан мэдээлэх систем гэх мэт/ ✓ Биологийн төрөл зүйлийн баримал ✓ Боловсролын хөтөлбөрт зориулсан хэсэг ✓ Хүүхдийн тоглоомын талбай ✓ Гэр бүлийн амрах, зугаалах хэсэг ✓ Авто зогсоол ✓ Үерийн усны далан, ус зайлуулах систем ✓ Усан оргилуур сонгодог аяар хөдөлгөөнтэй байх /пантом/ гэх мэт.
	Эдийн засгийн төсөв тооцоо	Төсвийг ESTIMATOR -pro программ болон бусад эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцож магадлал хийлгэнэ.
9	Бараа нийлүүлэлт	Гүйцэтгэгч нь баталгаажсан зураг, техникийн шийдэл, нарийвчилсан төсөвт үндэслэн бараа, тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.

		Нийлүүлэх бараа, тоног төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна: ✓ Шинэ, ашиглагдаагүй байх; ✓ Олон улсын болон холбогдох стандартын шаардлага хангасан байх; ✓ Үйлдвэрлэгчийн баталгаат хугацаатай байх; ✓ Засвар үйлчилгээ, сэлбэгийн олдоцтой байх; ✓ Ашиглалтын заавар, техникийн баримт бичигтэй байх. Гүйцэтгэгч дараах ажлыг гүйцэтгэнэ: ✓ Бараа, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, худалдан авах; ✓ Тээвэрлэх, гаалийн бүрдүүлэлт хийх; ✓ Нийлүүлэх; ✓ Сав баглаа боодол, хамгаалалтыг бүрэн хангах. *Захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолт, дэд даалгаварт тодорхой тусгасан.*
10	Угсралт, суурилуулалт	Гүйцэтгэгч нь захиалагчаар баталгаажсан зураг, техникийн шийдэлд үндэслэн нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулна. Үүнд: ✓ Интерьерийн хийц, үзүүллэг дэглэлт, тусгай тавилга угсрах; ✓ Үзмэрийн хорго, үзүүлгийн байгууламж суурилуулах; ✓ Мультимедиа, аудио-визуал, дижитал болон интерактив төхөөрөмж суурилуулах; ✓ Гэрэлтүүлгийн систем угсарч суурилуулах; ✓ Дуу, дүрсний систем суурилуулах; ✓ Цахилгаан, дата, сүлжээний холболт хийх; ✓ Аюулгүй байдал, хяналтын тоног төхөөрөмж суурилуулах; ✓ Тоног төхөөрөмжийн туршилтын бэлтгэл хангах. Угсралт, суурилуулалтын ажил нь музейн үзүүллэг дэглэлт, интерьер, мультимедиа болон дижитал систем, дом театр, лаборатори, сан хөмрөг, оффис, сургалт, номын сан, хүүхдийн болон нийтийн үйлчилгээний хэсэг, гадна талбайн тохижилт зэрэг төслийн хүрээнд нийлүүлэгдэх бүх бараа, тоног төхөөрөмжийг бүрэн хамарч, барилгын ашиглалтад саад учруулахгүйгээр хөдөлмөрийн болон галын аюулгүй байдлын шаардлагыг ханган гүйцэтгэгдэнэ. *Захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолт, дэд даалгаварт тодорхой тусгасан.*

11	Туршилт, тохируулга, ашиглалтад хүлээлгэн өгөх	Гүйцэтгэгч нь нийлүүлж суурилуулсан бүх бараа, тоног төхөөрөмжийг баталгаа болон зүгшрүүлэх, туршилт тохируулах хугацаанд тус бүр гүйцэтгэж ашиглалтад бэлэн болгож хүлээлгэн өгнө. Үүнд: ✓ Тоног төхөөрөмж, системүүдийн ажиллагааны туршилт, зүгшрүүлэлт хийх; ✓ Мультимедиа, дижитал болон аудио-визуал системийн тохируулга, зүгшрүүлэлт хийх; ✓ Гэрэлтүүлэг, дуу, дүрсний системийн тохируулга, зүгшрүүлэлт хийх; ✓ Системүүдийн уялдаа холбоог шалгах; ✓ Ашиглалтын заавар, техникийн баримт бичгийг хүлээлгэн өгөх; ✓ Ашиглалтын сургалт зохион байгуулах; ✓ Илэрсэн зөрчил, доголдлыг арилгах; ✓ Ашиглалтад хүлээлгэн өгөх акт үйлдэх. *Захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолт, дэд даалгаварт тодорхой тусгасан.*
12	Баталгаа, засвар үйлчилгээ	Гүйцэтгэгч нь нийлүүлж суурилуулсан бүх бараа, тоног төхөөрөмж, системийн баталгаа, засвар үйлчилгээг хариуцна. **Баталгаат хугацаа** ✓ Баталгаат хугацаа хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 12 сараас доошгүй байна. (өндөр дүнтэй худалдан авалт) ✓ Баталгаат хугацаанд илэрсэн гэмтэл, доголдлыг гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана. ✓ 12 сарын хугацааны дотор туршилт, тохируулга хийж акт үйлдэнэ. **Засвар үйлчилгээ** Гүйцэтгэгч нь засварын төвтэй байна. Баталгаат хугацаанд: **Дуудлагын засвар үйлчилгээ** ✓ Захиалагчийн мэдэгдэл хүлээн авснаас хойш – 24 цагийн дотор хариу өгөх; – 72 цагийн дотор засвар үйлчилгээ эхлүүлэх; ✓ Яаралтай саатлын үед боломжит хугацаанд түр арга хэмжээ авч хэвийн ажиллагааг сэргээнэ. **Төлөвлөгөөт үзлэг, үйлчилгээ** Баталгаат хугацаанд гүйцэтгэгч дараах төлөвлөгөөт үзлэг, үйлчилгээг хийнэ: ✓ Жилд дор хаяж 2 удаа бүрэн үзлэг хийх; ✓ Тохируулга, цэвэрлэгээ, программ шинэчлэл хийх; ✓ Илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах. **Сэлбэг, үйлчилгээний бэлэн байдал**

		✓ Гүйцэтгэгч нь нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн нэр төрлийн жагсаалт болон нийлүүлэгчийн мэдээллийг ирүүлнэ. Хамаарах хугацаа: хүлээлцэх акт үйлдсэнээс хойш 1 жил. ✓ Засвар үйлчилгээ үзүүлэх техникийн чадавх, мэргэжилтэнтэй байна. **Баталгаат хугацааны дараах үйлчилгээ** ✓ Баталгаат хугацаа дууссаны дараа захиалагчийн хүсэлтээр засвар үйлчилгээ үзүүлэх боломжтой байна. ✓ Баталгаат хугацааны дараах үйлчилгээний нөхцөл, үнийг гэрээгээр тохиролцоно. ✓ Баталгаат засварын хугацаа дууссаны дараа сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний гэрээг байгуулан ажиллах. *Захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолт, дэд даалгаварт тодорхой тусгасан.*
13	Гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. **Зураг, техникийн шийдэл боловсруулах** ✓ Гэрээ байгуулснаас хойш хуанлын 45 хоногийн дотор зураг төсөл, техникийн шийдлийг боловсруулж захиалагчаар батлуулж магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулна. **Бараа нийлүүлэлт** ✓ Баталгаажсан зураг, техникийн шийдэлд үндэслэн нийлүүлэлтийн үе шатны хуваарийг захиалагчид ирүүлнэ. **Угсралт, суурилуулалт** ✓ Угсралт, суурилуулалтын ажлын хуваарийг захиалагчид хүргүүлэх. **Туршилт, тохируулга, ашиглалтад хүлээлгэн өгөх** ✓ Туршилт, тохируулга хийж, ашиглалтад хүлээлгэн өгөх ажлыг 15 хоногийн дотор гүйцэтгэнэ. ✓ Бараа тоног төхөөрөмжийн зүгшрүүлэлтийн хугацааг баталгаат хугацаанд тооцохгүй болно. **Нийт гүйцэтгэх хугацаа** ✓ Гэрээ байгуулснаас хойш 18 сар *Захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолт, дэд даалгаварт тодорхой тусгасан.*
14	Хүлээлгэн өгөх баримт бичиг	Гүйцэтгэгч нь бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөхдөө дараах баримт бичгийг захиалагчид хүлээлгэн өгнө. **Зураг, техникийн баримт бичиг** ✓ Баталгаажсан зураг, төсөв, техникийн шийдлийн иж бүрдэл, магадлалын дүгнэлт;

		✓ Нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн жагсаалт; ✓ Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, паспорт. **Ашиглалт, үйлчилгээний баримт бичиг** ✓ Ашиглалтын гарын авлага; ✓ Засвар үйлчилгээний заавар; ✓ Сургалтын материал. **Баталгааны баримт бичиг** ✓ Баталгааны бичиг; ✓ Үйлдвэрлэгчийн сертификат, баталгаажуулалт; ✓ Сэлбэг хэрэгслийн мэдээлэл. **Гүйцэтгэлийн баримт бичиг** ✓ Туршилт, тохируулга, зүгшрүүлэлтийн тайлан; ✓ Илэрсэн зөрчил арилгасан тухай акт; ✓ Ашиглалтад хүлээлгэн өгөх акт. *Баримт бичгийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.*
15	Бусад нөхцөл	**Хамтын ажиллагаа** ✓ Гүйцэтгэгч нь ажлын явцад захиалагч болон ашиглагч байгууллагатай тогтмол зөвшилцөж ажиллана. ✓ Шаардлагатай тохиолдолд ажлын явцын тайлан, танилцуулгыг гаргана. **Хөдөлмөрийн аюулгүй байдал** ✓ Угсралт, суурилуулалтын ажлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган гүйцэтгэнэ. ✓ Барилгын ашиглалтад саад учруулахгүйгээр ажлыг зохион байгуулна. **Байгаль орчин, хамгаалалт** ✓ Ажлын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээ авна. ✓ Сав баглаа боодол, хог хаягдлыг зохих журмын дагуу зайлуулна. ✓ Захиалагчийн боловсруулсан сав баглаа боодолд тавигдах шаардлага, дэд ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг бүрэн хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлнэ. **Сургалт** ✓ Ашиглагч байгууллагын ажилтнуудад тоног төхөөрөмжийн ашиглалт, анхан шатны засвар үйлчилгээний сургалт зохион байгуулна. ✓ Захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолт, дэд ажлын даалгаварт тусгасан сургалт зохион байгуулах мэдэгдэл ирүүлнэ. **Хариуцлага** ✓ Гүйцэтгэгч нь нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмж, суурилуулалтын ажлын чанарыг бүрэн хариуцна.

Захиалагчийн боловсруулсан техникийн тодорхойлолт, дэд даалгаварт тодорхой тусгасан.

Санхүүгийн чадавхын шаардлага:

1. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2022, 2023, 2024 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувь болон түүнээс багагүй байна.
2. Төслийг тасралтгүй явуулахад шаардлагатай мөнгөн хөрөнгийн хэмжээ багцын батлагдсан төсөвт өртгийн 50 болон түүнээс багагүй байна.
3. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх ба арилжааны банкнаас олгох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолтоор баталгаажсан байна. /нэмэлт

Техникийн чадавх болон туршлагын шаардлага:

Багц-01: Музейн үзүүллэг дэглэлт, үзмэрийн интерьер, үзүүлэнгийн тоноглол, дагалдах ажил, үйлчилгээд хамаарах

Хүний нөөцийн шаардлага:

№	Албан тушаал	Тоо	Мэргэжил боловсрол	Ажилласан жил	Туршлага
1	Төслийн менежер	1	Төслийн менежмент, барилгын менежмент эсхүл барилгын инженерийн чиглэл	10 болон түүнээс дээш жил	3,000,000 долларын төсөв өртөгтэй төсөл амжилттай удирдаж байсан туршлагатай байх.
2	Барилгын менежментийн инженер	1	Барилгын менежмент эсхүл инженерийн чиглэл	5 болон түүнээс дээш жил	Мэргэжлийн дунд/дээд зэрэгтэй
3	Дотоод заслын инженер	3	Архитектурын чиглэл	5 болон түүнээс дээш жил	Дотоод заслын зураг төсөл, шийдэл боловсруулж байсан
4	Үзэсгэлэнгийн инженер	1	Урлаг, гар урлалын чиглэл	5 болон түүнээс дээш жил	Урлаг, гар урлалын шийдэл, гүйцэтгэл дээр ажилласан
5	Архитектор	2	Мэргэшсэн ба түүнээс дээш зэрэгтэй	5 болон түүнээс дээш жил	Музейн чиглэлээр мэргэшсэн байх
6	Цахилгааны инженер	2	Цахилгааны инженер /Мэргэшсэн ба түүнээс дээш зэрэгтэй/	5 болон түүнээс дээш жил	Мэргэшсэн болон түүнээс дээш зэргийн хүчин төгөлдөр гэрчилгээ ирүүлнэ. Музейн тусгай гэрэлтүүлгийн ажлын туршлагатай байх
7	Халаалт, агаар сэлгэлт инженер	2	Халаалт, агаар сэлгэлтийн инженер эсхүл Дулааны инженер /Мэргэшсэн ба түүнээс дээш зэрэгтэй байх/	5 болон түүнээс дээш жил	Мэргэшсэн болон түүнээс дээш зэргийн хүчин төгөлдөр гэрчилгээ ирүүлнэ.
8	IT инженер	1	Мэргэшсэн ба түүнээс дээш зэрэгтэй	5 болон түүнээс дээш жил	Мэргэшсэн болон түүнээс дээш зэргийн хүчин төгөлдөр гэрчилгээ ирүүлнэ.
9	Мултимедиа инженер	1	AR/VR интерактив дэлгэц суурилуулах туршлагатай	5 болон түүнээс дээш жил	Хүчин төгөлдөр диплом ирүүлнэ. Музейн тусгай гэрэлтүүлгийн ажлын туршлагатай байх
10	Мультимедиа дизайнер	1	AR/VR интерактив дэлгэц дээр ажиллаж байсан туршлагатай	3 болон түүнээс дээш жил	Хүчин төгөлдөр диплом ирүүлнэ.
	Нийт ИТА тоо	18			

Оролцогчид тавигдах шаардлага

Үзүүллэг

Ижил төстэй ажлын туршлага:

Багц-01: Музейн үзүүллэг дэглэлт, үзмэрийн интерьер, үзүүлэнгийн тоноглол, дагалдах ажил, үйлчилгээ багцад:

Сүүлийн 3 жил буюу 2022, 2023, 2024 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа ижил төстэй бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн байх.

Ижил төстэй бараа, ажил, үйлчилгээ гэдэгт дараахын нийлбэрээр тооцно.

		✓ 12,000 м^2 талбайд Байгалийн түүхийн музей эсхүл Шинжлэх ухааны музейн үзүүллэг дэглэлт; ✓ Олон улсын стандарт бүхий үзэсгэлэнгийн танхим (2000 м^2-аас доошгүй)-ын үзүүллэг дэглэлт; ✓ Чулуужсан олдвор (палеонтологи, геологи, биологи)-ын бэхэлгээ болон орон зайн дэглэлт, хадгалалт хамгаалалтын чиглэлээр үзүүллэг дэглэлт гүйцэтгэсэн байна. Багц-02: Музейн үйл ажиллагааг дэмжих ажлын байрны тоноглол, тавилга Багц-03: Музейн үйл ажиллагааг дэмжих ажлын байрны техник хэрэгсэл Багц-04: Музейн зочин үйлчилгээ, нийтийн хоолны хэсгийн тоног төхөөрөмж, тавилга Багц-05: Музейн ашиглалтад шаардлагатай тээврийн хэрэгсэл Сүүлийн 3 жил буюу 2022, 2023, 2024 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна. **Нийтлэг шаардлага:** Байгалийн түүхийн музейн зураг төсөл/үйлдвэрлэл, үндэсний болон гадаад улсын музейн төслүүдийг амжилттай дуусгасан туршлагатай байх. **Ажлын даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, графикийг оновчтой төлөвлөсөн байдлыг дараах байдлаар ирүүлнэ.** - **Арга зүй**: Төслийг тогтоосон хугацаанд, төсөвт багтаан дуусгах арга зүйг эзэмшсэн байх. - **Технологи**: Барилгын ашиглалтын бүхий л үе шатыг хамарсан BIM Level 3 түвшний 'Digital Twin' загварчлалыг ашиглан гүйцэтгэнэ. - Үзмэрийн гэрэлтүүлгийн угсралт, серверийн тохиргоо болон хяналтын системийг иж бүрнээр нь нэвтрүүлэх чадамжтай байх. - Агааржуулалт, хөргөлтийн системийн (HVAC) тоног төхөөрөмжийн суурилуулалт, BMS (Building Management System) хяналтын удирдлага болон серверийн тохиргоог гүйцэтгэх чадамжтай байх.

ХЯНАСАН:

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — Ц.АРИУНСАНАА

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ СОЁЛЫН ӨВИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Б.ДАВААЦЭРЭН

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ — А.АМГАЛАНЗАЯА

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — С.ХЭРЛЭН

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ СОЁЛЫН ӨВИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — П.АЛДАРМӨНХ

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ЦАХИМ ХӨГЖИЛ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Б.ТӨГӨЛДӨР

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР — Б.ЗОЛБОО

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ МУЗЕЙН АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ — Т.БАДРАЛ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ҮЗҮҮЛЛЭГ, ҮЗЭСГЭЛЭНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — О.СОРОНЗОНБОЛД

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА — Ж.МЯГМАРСҮРЭН

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ МУЗЕЙН АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ БИЧИГ ХЭРЭГ — Б.ТОДГЭРЭЛ

___o0o___